

БАТЛАВ

ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН

2025 оны 11 дүгээр сарын 03.

ATA14401 9025010818 5890683

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 11 дүгээр сарын 03

Дугаар 09

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 15:30 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн захиргааны байрны 201 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Байгууллагын нийт хөрөнгөнд ашигласан жил дуусаж үлдэх өртөггүй болсон боловч ашиглаж байгаа хөрөнгийг дахин үнэлэх, эвдрэл гэмтэлтэй ашиглах боломжгүй эд хөрөнгийг данснаас хасах саналыг боловсруулан Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 11 дүгээр сарын 03

Дугаар 09

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот хурлын танхимд 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 15:30 цагт эхэлж 16:30 цагт дуусгав.

Хуралд:

Дарга	Н.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга	О.Чулуун-Эрдэнэ
Гишүүд	Г.Ганцэцэг
	Б.Түмэнжаргал
	Б.Болортуяа нар оролцов.

Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Байгууллагын нийт хөрөнгөнд ашигласан жил дуусаж үлдэх өртөггүй болсон боловч ашиглаж байгаа хөрөнгийг дахин үнэлэх, эвдрэл гэмтэлтэй ашиглах боломжгүй эд хөрөнгийг данснаас хасах саналыг боловсруулан Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

СОНССОН НЬ: Өмчийн харилцааны газраас хуучин өмчийн системийг шинэчилж, шинэ систем нэвтрүүлэхтэй холбоотойгоор төрийн өмчит байгууллагуудад сургалт зохион байгуулсан. Үлдэх өртөггүй, ашигласан жил дууссан эд хөрөнгийн ашиглаж байгаа бол дахин үнэлэх, эс хүл данснаас хасах ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Н.Пүрэвсүрэн: 2025 оны хагас жилийн тооллогын комиссийн тайланд 10 төрлийн эд хөрөнгийг данснаас хасах санал оруулсан байна. Миний ойлгож байгаагаар эдгээр хөрөнгөнүүд нь ашиглах боломжгүй болсон байх. Мөн манай байгууллагад ашигласан жил дууссан, үлдэх хөрөнгөгүй нэлээн олон тооны тоног төхөөрөмж, эд хөрөнгө байгаа. Нярав Э.Ундармаа болон нягтлан бодогч Г.Ганцэцэг нар программд бүртгэлтэй байгаа эд хөрөнгө, тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж ирүүлсэн байна. Манай зөвлөл ярилцаад данснаас хасах болон цаашид ашиглах боломжтой хөрөнгөнүүдээ ялгаад дахин үнэлэн дансны үнэ, ашиглах жилийг шинэчлэн хийцгээе.

Б.Болортуяа: За ойлголоо. Жагсаалтыг хүлээн авсан. Бүгдээрээ нэг бүрчлэн тойрч үзээд ашиглах боломжтой, ашиглах боломжгүйгээр ангилаад, ашиглах боломжгүйг данснаас хасаж ашиглах боломжтойг дахин үнэлгээ хийцгээе.

О.Чулуун-Эрдэнэ: Жагсаалтаас харахад нийт 24 нэр төрлийн 33,604,600.00 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 37 нэр төрлийн 25,334,600.00 төгрөгийн тавилга, эд хогшил, 2 нэр төрлийн тээврийн 111,100,000.00 төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2 нэр төрлийн 1,570,000.00 төгрөгийн программ хангамж, нийт 171,609,200.00 төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгө үлдэх өртөггүй, ашигласан жил дууссан байна. Гэвч бидэнд эдгээрээс ашиглах боломжтой, одоо ч ашиглаж буй маш олон төрлийн эд хөрөнгө байна.

Б.Түмэнжаргал: Одоо бүгдээрээ ярилцаад нэг бүрчлэн үзэж ангилал хийцгээе. Ангилал хийхдээ бас тооллогын комиссийн саналыг харгалзаж үзэх хэрэгтэй гэж үзэж байна.

Г.Ганцэцэг: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолыг баримтлан холбогдох бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллана.

Н.Пүрэвсүрэн: Мэдээж тэгэлгүй яахав, бидэнд тооллогын комиссийн тайланд тусгагдсан санал байна. За ингээд ангиллаа эхэлцгээе.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 09 дүгээр хуралдаанаар гишүүд 100 хувийн ирцтэй хуралдаж нийт 9 нэр төрлийн эд хөрөнгийг данснаас хасах, 56 нэр төрлийн эд хөрөнгийг дахин үнэлж цаашид ашиглахаар,
- Дахин ашиглахаар шийдвэрлэсэн 56 нэр төрлийн эд хөрөнгөөс 20 нэр төрлийн машин тоног төхөөрөмжийг 2 жилээс илүүгүй хугацаагаар, 30 нэр төрлийн тавилга эд хогшлыг 2-5 жилийн хугацаатайгаар, 2 нэр төрлийн 2 тээврийн хэрэгслийг тус бүр 5 жилийн хугацаатайгаар, 2 нэр төрлийн 2 программ хангамжийг тус бүр 3 жилийн хугацаатайгаар дахин ашиглахаар шийдвэрлэлээ.
- Дээрх 56 нэр төрлийн эд хөрөнгө тус бүрд дахин үнэлгээг хийж үнэ тогтоов. Дахин үнэлэгдсэн эд хөрөнгийг жагсаалтыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт албан бичгээр хүргүүлэн тушаал шийдвэрийг гаргуулах,
- Данснаас хасах хөрөнгийг холбогдох бичиг баримтыг хавсарган Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэн шийдвэрийг авах,
- Дээд газраас шийдвэр ирсэн тохиолдолд өмчийн бүртгэлийн системд холбогдох журмын дагуу бүртгэж, цаашдын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Нарийн бичгийн дарга

Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан мэргэжилтэн/

